



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Архангай аймаг
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх
аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитындүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9 Завсрын аудитын үр дүн	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

2.Аудитын дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 162
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,081,392.43	80,353,272.43
35	БАРАА МАТЕРИАЛ	46,887,392.43	48,629,272.43
354	Хангамжийн материал	46,887,392.43	48,629,272.43
35410	Бичиг хэргийн материал	1,145,675.00	1,161,975.00
35420	Аж ахуйн материал	36,759,312.43	38,026,492.43
35430	Сэлбэг хэрэгсэл	4,805,000.00	6,575,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,625,000.00	1,100,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,552,405.00	1,765,305.00
36	НӨӨЦИЙН БАРАА	7,194,000.00	31,724,000.00
36300	Тэжээлийн нөөц	7,194,000.00	31,724,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,649,402,661.30	8,404,959,616.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,649,402,661.30	8,404,959,616.34
392	Биет хөрөнгө	1,629,492,827.87	8,386,199,782.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	954,763,697.92	954,763,697.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,791,302.10)	(41,786,869.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	114,434,700.00	80,644,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,777,751.02)	(66,569,884.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,784,766.71	68,974,151.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,420,372.76)	(20,828,287.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,583,266.79	72,847,982.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,355,594.65)	(44,820,467.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,120,633,068.68	1,157,971,679.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	(519,361,651.70)	(476,661,937.99)
393	Биет бус хөрөнгө	19,909,833.43	18,759,833.47
39301	Програм хангамж	7,224,500.00	5,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,188,666.57)	(3,864,166.53)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,874,000.00	16,874,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,703,484,053.73	8,485,312,888.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,703,484,053.73	8,485,312,888.77
51	Засгийн газрын хувь оролцоо	1,703,484,053.73	8,485,312,888.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	652,644,976.24	652,644,976.24
51101	Өмч: - төрийн	652,644,976.24	652,644,976.24
512	Хуримтлагдсан үр дүн	922,777,398.97	7,704,606,234.01
51210	Өмнөх үеийн үр дүн	922,777,398.97	922,777,398.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,061,678.52	128,061,678.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,703,484,053.73	8,485,312,888.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	725,195,952.00	7,372,785,934.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	247,785,526.00	6,917,470,869.00
120	Нийтлэг татварын бус орлого	247,785,526.00	6,917,470,869.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	247,691,876.00	25,522,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,930,750.00	25,522,200.00

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		6,891,948,669.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,410,426.00	455,315,065.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,143,276.00	35,721,965.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,786,976.00	11,281,456.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,356,300.00	24,440,509.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,267,150.00	419,593,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410,267,150.00	419,593,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	568,501,372.00	568,314,867.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,501,372.00	568,314,867.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,585,644.60	526,834,369.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,783,800.00	258,755,746.00
210101	Үндсэн цалин	256,773,800.00	237,139,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	
210104	Урамшуулал	4,750,000.00	6,616,446.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,260,000.00	15,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,484,214.60	33,568,264.00
210201	Тэтгэврийн даатгал	23,062,630.64	23,562,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,653,698.56	2,501,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,122,957.86	2,001,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,177.19	500,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,131,750.35	5,002,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,450,981.00	21,201,325.00
210301	Гэрэл, цахилгаан	4,638,505.33	4,995,537.00
210302	Түлш, халаалт	9,812,475.67	16,055,788.00
210303	Цэвэр, бохир ус	-	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,931,419.12	28,322,996.00
210401	Бичиг хэрэг	4,788,500.00	3,127,650.00
210402	Тээвэр, шатахуун	25,614,420.00	19,836,826.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,764,700.00	2,254,000.00
210404	Ном, хэвлэл	-	86,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,150,150.00	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,444,949.12	2,714,220.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	168,700.00	133,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,938,000.00	671,000.00
210604	Урсгал засвар	3,938,000.00	671,000.00
2107	Томилот, зочны зардал	1,637,000.00	694,000.00
210702	Дотоод албан томилот	1,637,000.00	694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,386,414.00	19,263,552.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,932,017.00	17,876,460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,020,000.00	1,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	50,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,087.00	130,092.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,148,310.00	95,000.00
210807	Газрын төлбөр	6,000.00	12,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,973,815.88	164,357,486.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,643,969.00	19,425,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	101,352,846.88	144,931,736.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,915,727.40	41,480,498.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,100,000.00	25,699,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,446,700.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,100,000.00	5,252,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,815,727.40	15,781,498.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,815,727.40	15,781,498.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	156,694,580.00	6,804,471,066.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	22,258,677.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	22,258,677.16
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(22,258,677.16)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	796,169,568.97	1,576,876,223.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	796,169,568.97	1,576,876,223.73
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	126,607,830.00	126,607,830.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	922,777,398.97	1,703,484,053.73
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	922,777,398.97	1,703,484,053.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	922,777,398.97	1,703,484,053.73
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,781,828,835.04	6,781,828,835.04
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,644,976.24	128,061,678.52	7,704,606,234.01	8,485,312,888.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	531,596,626.00	480,837,265.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,186,200.00	25,522,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,186,200.00	25,522,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,092,550.00	25,522,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,930,750.00	25,522,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,410,426.00	455,315,065.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,143,276.00	35,721,965.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,786,976.00	11,281,456.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,356,300.00	24,440,509.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,267,150.00	419,593,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410,267,150.00	419,593,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	470,598,876.00	450,038,565.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,598,876.00	450,038,565.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,683,148.60	408,558,067.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,783,800.00	259,139,300.00

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	256,773,800.00	237,139,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	383,554.00
210104	Урамшуулал	4,750,000.00	6,616,446.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,260,000.00	15,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,484,214.60	33,568,264.00
210201	Тэтгэврийн даатгал	23,062,630.64	23,562,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,653,698.56	2,501,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,122,957.86	2,001,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,177.19	500,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,131,750.35	5,002,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,285,981.00	19,676,325.00
210301	Гэрэл, цахилгаан	4,510,500.00	4,995,537.00
210302	Түлш, халаалт	11,775,481.00	14,530,788.00
210303	Цэвэр, бохир ус	-	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,477,800.00	21,679,130.00
210401	Бичиг хэрэг	3,303,800.00	2,998,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,367,520.00	12,697,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,350,000.00	2,254,000.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,472,480.00	829,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,784,000.00	2,800,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,825,800.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	3,777,100.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,637,000.00	694,000.00
210702	Дотоод албан томилолт	1,637,000.00	694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,663,553.00	32,001,048.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,111,156.00	30,534,456.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,020,000.00	1,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	50,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,087.00	209,592.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,246,310.00	95,000.00
210807	Газрын төлбөр	6,000.00	12,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,925,000.00	39,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,925,000.00	39,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,915,727.40	41,480,498.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,100,000.00	25,699,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,446,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,100,000.00	5,252,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,815,727.40	15,781,498.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,815,727.40	15,781,498.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>60,997,750.00</u>	<u>30,798,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,742,300.00	30,798,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,742,300.00	30,798,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,742,300.00	30,798,700.00
221001	Их засвар	2,331,000.00	10,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,789,000.00	1,129,900.00
223001	Бусад хөрөнгө	26,622,300.00	19,668,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(30,742,300.00)</u>	<u>(30,798,700.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,077,000.00	435,365,311.00	12,711,689.00	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,977,000.00	418,265,311.00	12,711,689.00	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,278,000.00	392,566,311.00	12,711,689.00	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,139,300.00	259,139,300.00	-	100.0
210101	Үндсэн цалин	237,139,300.00	237,139,300.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	383,554.00	(383,554.00)	#DIV/0!
210104	Урамшуулал	7,000,000.00	6,616,446.00	383,554.00	94.5
210105	Гэрээт ажлын хөлс	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,893,800.00	33,568,264.00	1,325,536.00	96.2
210201	Тэтгэврийн даатгал	24,888,200.00	23,562,664.00	1,325,536.00	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,501,400.00	2,501,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,001,100.00	2,001,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	500,300.00	500,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,002,800.00	5,002,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,391,000.00	19,676,325.00	1,714,675.00	92.0
210301	Гэрэл, цахилгаан	5,045,000.00	4,995,537.00	49,463.00	99.0
210302	Түлш, халаалт	16,196,000.00	14,530,788.00	1,665,212.00	89.7
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,391,500.00	21,608,130.00	3,783,370.00	85.1
210401	Бичиг хэрэг	2,927,500.00	2,927,500.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	14,000,000.00	12,697,310.00	1,302,690.00	90.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,364,000.00	2,254,000.00	110,000.00	95.3
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	829,320.00	2,370,680.00	25.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,215,400.00	5,998,700.00	216,700.00	96.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,130,000.00	1,129,900.00	100.00	100.0
210602	Тавилга	2,785,400.00	2,568,800.00	216,600.00	92.2
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	694,000.00	1,806,000.00	27.8
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	694,000.00	1,806,000.00	27.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,847,000.00	12,381,592.00	465,408.00	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,915,000.00	10,915,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,100,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	50,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,000.00	209,592.00	60,408.00	77.6

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	95,000.00	405,000.00	19.0
210807	Газрын төлбөр	12,000.00	12,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,400,000.00	39,000,000.00	3,400,000.00	92.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,000,000.00	39,000,000.00	3,000,000.00	92.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,699,000.00	25,699,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,699,000.00	25,699,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,446,700.00	20,446,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,252,300.00	5,252,300.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,100,000.00	17,100,000.00	-	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	17,100,000.00	17,100,000.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	17,100,000.00	17,100,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	448,077,000.00	435,365,311.00	12,711,689.00	97.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	370,953,800.00	409,843,111.00	(38,889,311.00)	110.5
132001	Орон нутгийн төсвөөс	370,953,800.00	409,843,111.00	(38,889,311.00)	110.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	77,123,200.00	25,522,200.00	51,601,000.00	33.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,496,000.00	25,522,200.00	(6,026,200.00)	130.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,690,456.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,690,456.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,690,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,000.00
210401	Бичиг хэрэг	71,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,619,456.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,619,456.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,721,965.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,721,965.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,281,456.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,440,509.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Төвшрүүлэх сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 5 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төвшрүүлэх сумын ЗДТГ нь тайлант жилд “Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжлийг тодорхойлж, хэрэгжилтийг ханган төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй хүргэх” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байсан бөгөөд 2022 оноос шинээр бодлогын баримт бичиг АРА-2022/89/НА-СТА-ТШЗ

ашиглаж эхэлсэн нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 448.1 сая төгрөгөөс 1%-иар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 6,781.8 сая төгрөгөөр буюу 79.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Бараа материал	54.1	80.3	26.2	32.6
Үндсэн хөрөнгө	1,649.4	8,405.0	6,755.6	80.4
Нийт хөрөнгө	1,703.5	8,485.3	6,781.8	79.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,703.5	8,485.3	6,781.8	79.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,703.5	8,485.3	6,781.8	79.9

3.5.1. Бараа материал эхний үлдэгдлээс 32.6 хувиар өссөн байна. Бараа материалын данс нь 54.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 78.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 52.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 80.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын данс эхний үлдэгдлээс өссөн нь сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,755.6 сая төгрөг буюу 80.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,649.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 30.8 сая төгрөгөөр, хандиваар 6,982.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд шилжүүлсэн 112.3 сая төгрөг, байгуулсан 144.9 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 8,405.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн данс эхний үлдэгдлээс өссөн нь УТХО-аар 6,701.6 сая төгрөгийн зам гүүрний байгууламж хүлээн авч бүртгэлд тусгасантай холбоотой байна. Мөн тайлант онд 177.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 66.4 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

3.5.3 Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 6,781.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	410.3	419.6	9.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	45.8	35.7	(10.1)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	21.3	24.4	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	247.7	6917.5	6,669.8
Үйл ажиллагааны орлого	725.10	7372.8	6,647.7
Бараа үйлчилгээний зардал	537.6	527.1	(10.5)
Урсгал шилжүүлэг	30.9	41.3	10.4
Үйл ажиллагааны зардал	568.5	568.4	(0.1)
Үндсэн хөрөнгө худалдсны гарз		-22.2	(22.2)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	156.60	6,782.20	6,625.6

Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос 6,782.2 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 504.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 56.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 448.1 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 448.1 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 371.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 57.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 25.5 сая төгрөгийн санхүүжилт авч 435.3 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 12.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 6.0 сая, урсгал үйл ажиллагаанаас 6.7 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 35.7 сая төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна. Үүнд:

1. Иргэд олон нийтээс 24.4 сая төгрөгийн өвс тэжээлийн орлого орсноос 18.4 сая төгрөгөөр сумын аюулгүй нөөцийг бүрдүүлж, 6.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.
2. Аймгийн Засаг даргаас ирсэн 10.1 сая төгрөгийн санхүүжилтийг өвс тэжээлийн нөөц болон ковидын бэлэн байдалд зориулан зарцуулсан байна.
3. ГБХЗХГ-аас ирсэн 0.5 сая төгрөгийн санхүүжилтийг хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан байна.
4. Аймгийн статистикийн хэлтсээс ирсэн 03.7 сая төгрөгийг жилийн мал тооллогод зориулан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 15.1-д заасны дагуу гамшгаас хамгаалах зардлаас 26.7 сая төгрөгийн санхүүжилт гарч голомтод ажилласан албан хаагчид болон ЭМТ, хэвтэн эмчлүүлэг нарын байр хоолны зардалд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 95.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 448.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 435.3 сая төгрөгийг зарцуулж, 97.2 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 12.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийн 10.0 хувийг эзэлж байна.
- Албан конторын тавилга худалдан авахад 2.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Албан томилолт, уралдаан тэмцээн, бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг гаргасан байна.
- Тус байгууллага нь албан ажлын 1 автомашинтай, үндсэн орон тооны 1 жолоочтой, шатахууны зардалд 12.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төвшрүүлэх сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь 21 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд батлагдсан төсвийн 10.0 хувь буюу 12.7 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

Төсвийн хөрөнгөөр 2.6 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төвшрүүлэх сумын ЗДТГ санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 2021.04.27-ны 21 тоот албан бичиг тоот бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тээвэр шатахуун түлш халаалтын зардлын зарцуулалтыг шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 1 албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 3.6 сая төгрөгийн алдаа нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 4.4 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Орлого үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд 0.4 сая төгрөгийн орлого зардал илүү тайлагнасныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

Түлш халаалтын зардлаас 1.0 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй материал авч нөөцөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Бараа материалын данстай холбоотой асуудал

Түлш халаалтын зардлыг шалгахад материалыг шаардах хуудасгүйгээр зарлага болгосон буюу анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны нотлох баримтыг бүрэн бүрдүүлж, иж бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Төвшрүүлэх сумын ЗДТГ	3	1.4	1	0.4	1	1.0			1	
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Төвшрүүлэх сумын ЗДТГ	2	2.6					1	2.6	1	
НИЙТ ДҮН		5	4.0	1	0.4	1	1.0	1	2.6	2	